



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.05 № 1/НАА-2024/13-УТА-НА-82
танай _____-ны № _____-т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
МОНГОЛЫН ХҮНИЙ ТӨЛӨӨ НАМД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Монголын хүний төлөө намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-

2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт


Монголын хүний төлөө намын аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Монголын хүний төлөө намын мөрийн хөтөлбөр / ⁴..... хуудас /-ийг хавсаргав.

Хувийг: Монголын хүний төлөө намд

Хувийг: Сэлэнгэ аймгийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА



**2024 ОНЫ
СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН СОНГУУЛИЙН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

1. НИЙГЭМ, ЭРҮҮЛ МЭНД, ХАЛАМЖИЙН БОДЛОГО

1.1. Эрүүл мэнд, урьдчилан сэргийлэх, чийрэгжүүлэх

- 1.1.1. Өвчин туссан хойно нь эмчлэх биш урьдчилан сэргийлж, хамгаалах бодлогыг чухалчилна.
- 1.1.2. Нийтийн биеийн тамирыг дэмжиж, шаардлагатай дэд бүтцийг хөгжүүлэх, хот суурин, хорооллын төлөвлөлтөд цэцэрлэгт хүрээлэн, гүйлт, дугуйн зам, усан сан зэргийг заавал тусгах хууль зүйн орчныг бүрдүүлэх бодлого баримтална.
- 1.1.3. ЭМД-ын оновчтой, үр дүнтэй, энэрэнгүй хувилбарыг боловсруулж нэвтрүүлэх бодлого баримтална.

1.2. Хүн амын өсөлт

- 1.2.1. Хүн амын өсөлт нь орон нутгийн хөгжлийн чухал хэсэг бөгөөд эдийн засгийн эрчимтэй өсөлтийн гол үзүүлэлт гэж үзнэ.
- 1.2.2. Эдийн засгийн чадавх сайжирч, иргэдийн ирээдүйдээ итгэх итгэл нэмэгдэх нь хүн амын өсөлтөд сайнаар нөлөөлөх тул урамшууллын оновчтой бодлого баримтална.

1.3. Ажилгүйдлийг бууруулах бодлого

- 1.3.1. Ажлын байрыг нэмэгдүүлэх бүхий л боломжийг эрэлхийлсэн бодлого баримтална /хүүхэд хүмүүжүүлэн, саатуулж, сургадаг цэцэрлэг, сургууль, өдөр өнжүүлэх нь хүүхдийн эцэг эхэд ажил хийх чөлөө зав олгох үүрэгтэй юм/.
- 1.3.2. Ажлын байр олноор бий болгож, төсвийн ачааллыг багасгадаг жижиг, дунд аж ахуйнуудад татварын хөнгөлөлт, санхүүгийн урамшууллаар дэмжлэг үзүүлэх бодлого баримтална.
- 1.3.3. Боловсролын бодлого, мэргэжлийн сургалт, сургалтын зээлийн бодлого зэрэг нь ажилгүйдлийг багасгахад чиглэгдэх бодлого, зорилгыг хэрэгжүүлэх эрхзүйн таатай орчныг бүрдүүлэхийн төлөө ажиллана.

1.4. Нийгмийн халамж

- 1.4.1. Нийгмийн халамж нь зорилтот бүлэгт чиглэн, хүрч байх бүртгэл тооцооны тогтолцоог бүрдүүлэн халамжийн хавтгайрсан бодлогоос зайлсхийж, бэлэнчлэх сэтгэлгээг багасгах бодлого баримтална.
- 1.4.2. Бие дааж амьдрах болон хөдөлмөрлөх чадвар нь хязгаарлагдмал иргэдийг айх аюулгүй, санаа амар амьдрах нийгмийн тогтолцоог бүрдүүлэх бодлого баримтална.

2. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БОДЛОГО

2.1. Ерөнхий боловсрол

- 2.1.1. Боловсролын салбар онцгой салбар, онцгой хандлага, бодлого шаардлагатай суурь салбар. Он цагийн хэлхээсээр харвал ирээдүйг бүтээгч салбар, бид хэн байх, бид юунд бэлэн байх, бид өрсөлдөх чадвартай эсэх, бид хөгжиж чадах эсэхийг тодорхойлох онцгой өвөрмөц салбар гэдгийг ухааран хандах болно.
- 2.1.2. Боловсролын салбарыг онцгойлон анхаарах бодлого хэрэгжүүлнэ. Ирээдүйд улс орны хөгжлийг тодорхойлох иргэдийг хүмүүжүүлэх, монголчууд юунд бэлдэх, дэлхийн түвшинд өрсөлдөх чадвартай болгох, цаашдын эрчимтэй хөгжлийг тодорхойлогч салбар хэмээн үзнэ.

- 2.1.3. Эрдэмтэн мэргэд, багш сурган хүмүүжүүлэгч нарын хүчээр сургуулийн өмнөх, бага, дунд, ахлах сургуулийн боловсролын хөтөлбөрийг шинэчлэх замаар шинжлэх ухаанч, цогц бодлогыг хэрэгжүүлэх санал санаачилгыг гарган хэрэгжүүлнэ.
- 2.1.4. Боловсролын салбарын хөгжлийн хөшүүрэг нь багш, сурган хүмүүжүүлэгчдийн хөдөлмөрийн үнэлгээ бөгөөд багш, сургагчдын нийгмийн баталгааг сайжруулснаар тэдний нэр хүнд, боловсрол, мэдлэг дээшилж, боловсролтой, соёлтой **МОНГОЛ ХҮН** бэлтгэх тогтолцоо гэж үзнэ.
- 2.1.5. Орон нутгийн хүүхэд, залуучуудын суурь боловсрол эзэмших, сурч хүмүүжих орчин ахуйг ижил тэгш, чанартай нөхцөлөөр хангах чиглэлийг барьж ажиллана.
- 2.1.6. Бидний ирээдүй үеийн хүмүүжил, биеэ авч явах байдал, хүсэл сонирхолд багш нарын жендерийн харьцаа нөлөөлж байгаа гэж үзэж байгаа тул эрэгтэй багш нарын тоог нэмэгдүүлэх үр дүнтэй бодлого баримтална.

2.2. Мэргэжлийн сургалт

- 2.2.1. Мэргэжлийн сургалт, боловсролын хандлагад эрс өөрчлөлт гаргах асуудлыг уламжлан шийдвэрлүүлнэ.
- 2.2.2. Мэргэжлийн боловсролтой иргэдийг тогтвортой ажлын байраар хангах оновчтой бодлого баримтална.
- 2.2.3. Орон нутгийг үйлдвэрлэгч аймаг болгоход шаардлагатай инженер, техникч, мэргэжлийн ажилчид бэлтгэх чиглэлд өндөр ач холбогдол өгч, бодлого боловсруулахад анхаарна.

2.3. Соёл

- 2.3.1. Үндэсний соёл нь монгол үндэстний оршин тогтнох, уламжлалт онцлогоо хадгалах нандин дархлаа бөгөөд дэлхий дахинд биднийг таниулах хүчирхэг хэрэгсэл хэмээн үзнэ.
- 2.3.2. Соёл урлаг нь хүн төрөлхтний гоо зүй, гоо сайхны мэдрэхүйг хөглөдөг төдийгүй үндэсний өв уламжлалыг таниулах, эх оронч үзэл, бахархлыг төлөвшүүлэх онцгой салбар гэж үзэн бодлогоор дэмжиж, хөгжүүлэх чиглэл баримтална.
- 2.3.3. Кино, драмын урлагийн салбар нь арилжааны чиглэлтэй, зөв хүмүүжил, ёс суртахуун, эх оронч үзэл, үндэсний бахархлыг түгээн дэлгэрүүлэхийг дэмжиж ажиллана.

2.4. Шинжлэх ухаан

- 2.4.1. Монгол хэл нь монгол сэтгэлгээний үндэс тул эх хэлээ хамгаалах, зөв дэлгэрүүлэх, хөгжүүлэх бодлого баримтална.
- 2.4.2. Орон нутаг дахь түүх, археологийг аялал жуулчлалтай хослуулан хөгжүүлэх бодлого баримтална.

2.5. Спорт

- 2.5.1. Нийтийн биеийн тамирыг далайцтай хөгжүүлэх нь бүх нийтийн эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэх төдийгүй дэлхийн түвшинд амжилт гаргах

авьяаслаг тамирчдыг бэлтгэх суурь хэмээн үзэж, тэдний амжилтаас улбаалан, улс үндэстнээ дэлхий нийтэд сурталчлан, таниулах бодит үйл хэрэг болгоно.

2.5.2. Мэргэжлийн болон их спортыг дэмжих бодлого баримтална.

3. ЭДИЙН ЗАСАГ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БОДЛОГО

3.1. Төсөв, санхүү

- 3.1.1. Эдийн засаг үйлдвэрлэлийн бодлогын шинэчлэл, сайжруулалтын хүрээнд түүхий эд дээр суурилсан үйлдвэрлэлийг дэмжих, нөхөн сэргээгдэх баялгийн ашиглалтыг сайжруулах, уул уурхайн өгөөжийг нийтээр шударгаар хүртэх бодлого баримтална.
- 3.1.2. Орон нутгийн төсөв бүрдүүлэхийн зэрэгцээ аймгийн дотоодын зах зээл, хүнсний аюулгүй байдлыг давхар хамгаалж байх төсвийн бодлого баримтална.
- 3.1.3. Банк санхүүгийн салбарыг эрүүл, ёс зүйтэй шударгаар ажиллах, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн таатай нөхцөл бүрдүүлэх чиглэлийг баримтална.
- 3.1.4. Эдийн засаг, үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор гаалийн, онцгой, ашгийн татварын зохистой бодлого баримтална.
- 3.1.5. Жижиг аж ахуйн нэгжүүд татвар төлж, төсөв бүрдүүлэхээс гадна ажлын байр олноор бий болгодог онцлогийг харгалзаж дэмжлэг үзүүлэх чиглэл баримтална.

3.2. Хөдөө аж ахуй

- 3.2.1. Хөдөө аж ахуй, мал аж ахуй, газар тариалан нь улсын хүнсний аюулгүй байдлыг хангаж, хүн ардын эрүүл, урт наслалтын үндэс гэж үзнэ.
- 3.2.2. Орон нутагт өсөж, үрждэг баялаг болох мал сүргийг үр дүнтэй, зөв зохистой хөгжүүлснээр өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх бөгөөд ажлын байр бий болгох, төсвийн орлогыг нэмэгдүүлэх эх үүсвэр гэж үзэн дэмжиж ажиллана.
- 3.2.3. Нүүдлийн мал аж ахуй нь эрчимжүүлсэн мал аж ахуйтай зэрэгцэн хөгжиж, давуу талаа илэрхийлэн өрсөлдөх ёстой уламжлалт суурь салбар мөн гэж үзнэ.
- 3.2.4. Мал эмнэлгийн нэгдсэн бодлого, нэгдсэн мэдээлэл, нэгдсэн хяналт, нэгдсэн хангалт, нэгдсэн сүлжээгээр мал сүргийг эрүүл байлгаж, дотоодын болон экспортын чанар шаардлагыг хангана гэж үзнэ.
- 3.2.5. Малчин-үйлдвэрлэгч-борлуулагч гэсэн хамтарсан хэлбэрээр ажиллах хоршооллын бодлогыг дэмжинэ.

3.3. Газар тариалан

- 3.3.1. Тариалангийн аж ахуй нь орон нутгийн хүнсний аюулгүй байдлыг хангаж, хүн ардын эрүүл, урт наслалтын үндэс гэж үзнэ.
- 3.3.2. Экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих бодлого баримтална.

3.4. Аж үйлдвэр

- 3.4.1. Дэлхийн нийт хэрэглээний зах зээлийн 25%-ийг бүрдүүлдэг том гүрнүүдийн дунд оршдог давуу талаа ашиглан үйлдвэрлэгч, экспортлогч аймаг болох бүрэн боломжтой гэж үзнэ.
 - 3.4.2. Дотоодын түүхий эдийн үйлдвэрлэл, боловсруулалтыг түлхүү дэмжих бодлого баримтална.
 - 3.4.3. Байгальд хор хөнөөлгүй, технологийн дэвшилтэт үйлдвэрүүдэд дэмжлэг үзүүлэх бодлого баримтална.
- 3.5.** Худалдаачид нь нийгмийн эрчимтэй хөгжилд томоохон хувь нэмэр оруулдаг бөгөөд зах зээлийг соргогоор мэдэрч зохицуулах, судлах, үйлдвэрлэл хөгжүүлэх томоохон хүчин болохын хувьд үйл ажиллагааг нь дэмжиж, борлуулалтыг нэмэгдүүлэх бодлого баримтална.

3.6. Уул уурхай

- 3.6.1. Байгалийн бүх баялаг ард түмний өмч гэсэн Монгол улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалаар хариуцлагатай уул уурхайн хөгжлийг зохицуулна.
- 3.6.2. Олон тооны, замбараагүй, үр ашиг нь тодорхойгүй, хууль зөрчсөн /гол мөрний ай сав, ус ундарга, бэлчээр, ард түмний уламжлалт шүтлэг бүхий газар нутаг бохирдуулсан/ уурхайнуудыг цэгцлэх бодлого баримтална.

3.7. Эрчим хүч

- 3.7.1. Эрчим хүчний үйлдвэрлэл, түгээлт, борлуулалтад төрийн мэдлийг 50%-иас доош буулгахгүй байх стратегийн бодлогыг дэмжиж ажиллана.
- 3.7.2. Бүх төрлийн эрчим хүчний үйлдвэрлэлийг дэмжих ба сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэл баримтална.
- 3.7.3. Улс орныг хөгжүүлэхэд хангалттай эрчим хүч үйлдвэрлэх ба эрчим хүчний салбарыг экспортын орлого бүрдүүлэх томоохон эх үүсвэр гэж үзнэ.

3.8. Зам тээвэр, дэд бүтэц

- 3.8.1. Аймаг, орон нутагт тохиромжтой тээврийн салбарыг дэмжиж ажиллана.
- 3.8.2. Ард нийтийн ая тухтай амьдрах эрхийг хангах зорилгоор аймгийн төв, сум, суурин газруудын тухайн нөхцөлд нь тохиромжтой инженерийн дэд бүтцүүдийг бий болгох бодлого баримтална.

3.9. Барилга, хот байгуулалт

- 3.9.1. Аймгийн төв, сум, суурин газруудын төлөвлөлтийг сайжруулж, холбогдох чанар стандартыг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллана.
- 3.9.2. Амины орон сууцтай болох дэд бүтцийг хөгжүүлж бүтээлч дунд давхарга нь өөрийн байшинд тухтай амьдардаг дэлхийн жишгийг хэрэгжүүлэх бодлого баримтална.

3.10. Аялал жуулчлал

- 3.10.1 Аялал жуулчлал нь ажлын байр олноор бий болгодог, соёлын болон бусад харилцааг хөгжүүлдэг чухал салбар хэмээж сайшаан дэмжиж ажиллана.

4. ТӨРИЙН БАЙГУУЛАЛТ, ХУУЛЬ ЗҮЙН БОДЛОГО

4.1. Төрийн алба

- 4.1.1. Орон нутгийн төрийн албыг цомхон, чадварлаг байлгах бодлого баримталж, Монгол төрийн бахархлыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.
- 4.1.2. Төрийн алба нь Үндсэн хуульд заасан зарчмын дагуу, Үндсэн хуульд заасан үүргээ гүйцэтгэдэг иж бүрдэл байх ёстойг чухалчилж ажиллана.

4.2. Хяналтын тогтолцоо

- 4.2.1. Төрийн бүх байгууллагууд үнэнч шударга, алдаагүй, зөв зохистой ажиллах үндсэн нөхцөл нь хараат бус, хөндлөнгийн хяналт, хариуцлагын тогтолцоо гэж үзнэ.
- 4.2.2. Хүний эрхийг хангах, хамгаалахад чиглэсэн хууль эрх зүйг сахиулдаг иргэний хяналтын тогтолцоог бий болгохыг зорьж ажиллана.

4.3. Шүүх засаглал

- 4.3.1. Монгол улсын нэрийн өмнөөс төрийн төлөөлөл шүүгч, ард түмний төлөөлөл нар хамтран шийдвэр гаргадаг тогтолцоог сэргээх асуудлыг эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.
- 4.3.2. Шүүхийн байгууллагыг шударга, тэнцвэртэй байлгах зорилгоор төрийн төлөөлөл болох шүүгч нь ардын төлөөлөгчтэй хамтран, хараат бус, шударга шийдвэр гаргадаг байх эрхзүйн орчныг бүрдүүлэх асуудлыг эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.
- 4.3.3. Хүн өөрийгөө болон бусдыг өмгөөлөх эрхийг чөлөөтэй болгох асуудлыг эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.

4.4. Хүчний байгууллагын шинэчлэл

- 4.4.1. Хууль хяналтын байгууллагууд “Гүйцэтгэл - цагдаа, хяналт - прокурор, шийдвэр - шүүх” гэсэн схемийн дагуу хараат бус, шударгаар үйл ажиллагаа явуулдаг байх хууль эрхзүйн таатай орчныг бүрдүүлэхийг чухалчилна.

5. АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД ХАРИЛЦААНЫ БОДЛОГО

5.1. Батлан хамгаалах

- 5.1.1. Хугацаат цэргийн алба нь батлан хамгаалахын үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ залуучуудыг эх оронч сэтгэлтэй, бие бялдар, хүмүүжлийн өв тэгш хөгжилтэй, хамтран ажиллах чадвартай, бүтээн байгуулах тэмүүлэлтэй болгох сургалт хүмүүжлийн оновчтой хөтөлбөр гэж үзнэ.

5.2. Гадаад харилцаа

- 5.2.1. Аймаг, орон нутгийн дипломат харилцаа нь аюулгүй байдал, тусгаар тогтнолыг хангах, бүх салбар дахь харилцааг дэмжих, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилго гэж үзнэ.
- 5.2.2. Дэлхийн аль ч улсад Монгол улсын иргэний эрхийг хангах, хамгаалах бодлогыг чухалчилна.

5.3. Гадаадын хөрөнгө оруулалт

- 5.3.1. Монгол хүний хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх дэлхийн түвшинд дүйцүүлэх гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого баримтална.

5.4. Гадаад худалдаа

- 5.4.1. Мөнхийн 2 хөрштэйгөө харилцан ашигтай, оновчтой харилцаа, худалдааны бодлого баримтална.
- 5.4.2. Гадаад худалдааны гэрээ, бодлогоор дотоод үйлдвэрлэлээ хөгжүүлэх чиглэл, захиалга хийх асуудлыг эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.